

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өвөрхангай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨВА-2026/17/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Арвайхээр хот

2026 он

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: О.Батжаргал
Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn
Аудитын менежер: П.Хорлоосүрэн
Утас: 70323833 Цахим хаяг: KhorloosurenP@audit.gov.com
Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг
Утас: 70323108 Цахим хаяг:
Erdenetsetsegb@audit.gov.mn
Аудитор: Э.Энхбаяр
Утас: 70323833 Цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.07.19 № 07
танай _____-ны № _____-г

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Г.ЭРДЭНЭБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Өвөрхангай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд улсын төсвөөс 2,645.8 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансаар 110.3 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. Үндсэн данснаас цалин, нийгмийн даатгалын шимтгэл, бараа үйлчилгээний зардлыг, харин нэмэлт санхүүжилтийн данснаас өрхийн судалгааны болон орон нутгийн нэмэгдлийн санхүүжилтийг зориулалтын дагуу тус тус зарцуулжээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант үеийн санхүүгийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байна. Бидний гаргасан тайланд материаллаг хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байж болно. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

6225010001

D:\Auditin gaza\baiguullagiin dotood barimt\A4

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР



О. БАТЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Үзүүлэлт		2024.12.31	2025.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	36,257.8	33,929.7
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,395,539.1	1,423,058.7
	Нийт хөрөнгийн дүн	1,431,797.0	1,456,988.4
	Нийт өр төлбөрийн дүн	1,200.0	5,461.7
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,430,597.0	1,456,988.4
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,431,797.0	1,456,988.4
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	2,368,933.8	2,692,840.3
	Үйл ажиллагааны зардлын дүн	3,891,130.2	4,300,808.3
	Үйл ажиллагааны үр дүн	2,449,551.1	2,670,503.2
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(80,617.3)	22,337.1
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,430,597.0	1,429,189.7
	Тайлант оны үр дүн	(80,617.3)	22,337.1
	Эцсийн үлдэгдэл	12,116,947.7	11,398,684.1
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,369,933.8	2,569,890.7
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,349,108.9	2,569,890.7
	Үйл ажиллагааны ЦМГ	19,824.9	-
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(19,824.9)	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,459,266.2	2,362,187.9
	Урсгал зардал	2,459,266.2	2,362,187.9
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,459,266.2	2,362,187.9
	Улсын төсвөөс санхүүжих	2,459,266.2	2,362,187.9
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Аудитаар нийт 0.1 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдаа илэрснээс аудитын явцад уг 0.1 сая төгрөгийн алдааг бүрэн залруулж, цаашид ижил төрлийн алдааг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгсөн болно.

Үүнд: Санхүүгийн тайланд хувь хүний орлогын албан татварын өр төлбөрийг бүртгээгүй байсан нягтлан бодох бүртгэлийн алдааг аудитын явцад залруулсан бөгөөд энэхүү алдаа нь алдаа, зөрчлийн дүнгийн ангилалд хамруулахгүй болно.

Аудитаар нийт 214.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 4.1 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 210.6 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт өгөгдөөгүй

5.2 Албан шаардлага

Албан томиллоор ажилласан хугацаанд 27 албан хаагчид 4050.0 мянган төгрөгийн хоолны мөнгийг олгосон байна.

5.3 Зөвлөмж

1. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд орлогын 161,467.6 мянган төгрөгийн 1 гүйлгээ, зарлагын 18,852.8 мянган төгрөгийн 2 гүйлгээ, хөрөнгө, мөнгө зарцуулах 30,321.8 мянган төгрөгийн 2 шийдвэр, худалдах, худалдан авах 1 гэрээг мэдээлээгүй, орлогын 7 гүйлгээ, зарлагын 1, хөрөнгө, мөнгөтэй холбоотой 2 шийдвэр 12 гэрээг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг тогтоосон хугацаанд нь шилэн дансны цахим системд байршуулж, олон нийтэд ил тод мэдээлэх шаардлагыг ханган ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Санхүүгийн тайланд ХХОАТ-ын өр төлбөр бүртгээгүй	1	117.8	1	117.8			1	117.8				
Дүн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Албан томиллоор ажилласан	1	4,050.0			1	4,050.0						

хугацаанд 27 албан хаагчид 4050.0 мянган төгрөгийн хоолны мөнгийг олгосон												
Дүн	1	4,050.0	0	0	1	4,050.0	0	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлээгүй.	1	210,642.2					1	210,642.2
Дүн	1	210,642.2	0	0	0	0	1	210,642.2
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	0	0	0	0	0	0	0	0
Нийт дүн	1	210,642.2	0	0	0	0	0	210,642.2

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

